

# ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

**“УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК**  
**2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

**АГУУЛГА**

<b>I. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>3</b>
Арилжаа	3
Тооцооны үйл ажиллагаа	4
Эрсдэлийн удирдлага	4
Арилжааны эрсдэлийн удирдлага	4
Тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага	5
Бүртгэл	5
Гишүүнчлэл	6
Журам, зохицуулалт	6
Системийн хөгжүүлэлт	6
<b>II. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>7</b>
Бизнес хөгжүүлэлт	7
Хамтын ажиллагаа	8
<b>III. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ</b>	<b>9</b>
ХЭХ-ийн үйл ажиллагаа	9
ТУЗ-ийн үйл ажиллагаа	10
<b>IV. САНХҮҮ</b>	<b>11</b>

## I. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Арилжаа

Тайлант хугацаанд анхдагч зах зээлд хувьцаа болон бондын арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 125 өдрийн арилжаа явагдаж, 108,000 ширхэг, 2,837,000.00 төгрөгийн үнийн дүнтэй хувьцааны арилжаа явагдсан байна. Энэ оны эхний хагас жилд “Анд Энерги” ХК-ийн AND хувьцааны дээд ханш 28 төгрөг, доод ханш 24 төгрөг, дундаж үнэ 26.27 төгрөг, 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хаалтын ханш 27 төгрөг байлаа.

2023 оны хамгийн өндөр дүнтэй арилжаа явагдсан сар нь 2 дугаар сар бөгөөд нийт 1,102,302 төгрөгийн үнийн дүнтэй арилжаа явагдсан байна. 2023 оны эхний хагас жилд арилжаанд дараах үнэт цаасны компани оролцсон.

*Хүснэгт 1. Хувьцааны хоёрдогч зах зээлд оролцсон үнэт цаасны компанийн идэвх*

№	ҮЦК-ийн нэр	Арилжааны дүн, төгрөг
1	“Ард Секюритиз ҮЦК” ХХК	2,837,000.00

Арилжааны бодит цагийн болон арилжааны дараах өдөр тутмын мэдээллийг бид [www.ubx.mn](http://www.ubx.mn) цахим хаягаар дамжуулан олон нийтэд тогтмол хүргэж байна. Мөн дотоод мэдээлэл эзэмшигчид болон арилжаанд оролцогч бусад этгээдүүд зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх үүднээс үнэт цаасны компаниуд болон үнэт цаас гаргагчтай хамтран арилжааны хяналтыг гүйцэтгэж байна.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 04 тоот тогтоолоор баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1 дэх заалтын дагуу 2023 оны арилжааны мэдээг долоо хоног, сар, улирлаар бэлтгэн СЗХ-д тогтмол хүргүүлэн ажиллаж байна. Эдгээр мэдээнд арилжааны статистик мэдээлэл, үнэт цаасны өсөлт бууралт, зах зээлийн үнэлгээний мэдээллээс гадна арилжааны шимтгэл, үнэт цаас гаргагчтай холбоотой ногдол ашиг, үнэт цаасны компаниудын зохицуулалттай этгээдийн үйлчилгээний хөлсний мэдээллийг тусган цахимаар болон биетээр хүргүүлдэг.

## Тооцооны үйл ажиллагаа


Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК нь 2023 оны эхний хагас жилд биржийн зах зээлд арилжаалсан хувьцааны нийт 198 хэлцлийн 2,837,000.00 төгрөг үнийн дүн бүхий тооцооны үйл ажиллагааг тайлант хугацаанд гүйцэтгэжээ. Биржээр арилжаалсан үнэт цаасны тооцооны үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт 2. Гишүүдийн хийж гүйцэтгэсэн тооцооны дүн

Тооцооны гишүүн	Тооцооны гишүүний төрөл	Үнэт цаасны тикер	Тооцооны дүн /төгрөг/
Ард Секюритиз ҮЦК	ТШГ	AND	5,674,000.00

## Эрсдэлийн удирдлага

Бирж нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг 3 түвшинд хэрэгжүүлдэг бөгөөд Биржийн мэргэжилтэн бүр хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллана. Биржийн эрсдэлийн удирдлага дараах бүтцийн дагуу хэрэгжиж байна.



## Арилжааны эрсдэлийн удирдлага

Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэхийн тулд биржийн арилжааны систем нь дотоод мэдээлэл эзэмшигчдийг бүртгэж, тэдэнд нээсэн дотоод мэдээлэл эзэмшигчийн дансаар хийгдсэн захиалга болон хэлцлийн жагсаалтыг тогтмол хянадаг. Үүний үр дүнд хяналт, шалгалтыг бодит цагийн горимоор болон арилжааны дараа хийх боломжтой болсон.

## Тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Бирж нь 2023 оны эхний хагас жилд тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд тооцооны гишүүдээс журамд заасны дагуу барьцаа, дэнчинг төвлөрүүлж, доод үлдэгдлийг заасан хэмжээнд тогтмол хангуулж ажиллалаа. Арилжаанд оролцож буй оролцогчдын байршуулах дэнчингийн хувь хэмжээг 20 хувиас доошгүй байхаар, барьцаа хөрөнгийн доод үлдэгдлийг тогтмол дүнгээр Тооцооны ерөнхий гишүүд 10,000,000 төгрөг, Тооцооны шууд гишүүд 2,000,000 төгрөг байхаар тогтоосон.

Түүнчлэн тайлант хугацаанд тооцооны гишүүд төлбөрийн чадварын эрсдэлд орсон тохиолдол гараагүй бөгөөд төлбөр хугацаандаа төлөгдөөгүй, хоцорсон зэрэг асуудал үүсээгүй.

## Бүртгэл

Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 23/22, Санхүүгийн Зохицуулах Хорооны Даргын 2022 оны 487 тоот тогтоолоор Биржийн Бүртгэлийн журамд хөрөнгө оруулалтыг сангийн төрөл болох хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын санг бүртгэхтэй холбоотой нэмэлт зохицуулалтыг оруулж батламжилсан. Тус журмын хүрээнд Инвекор Ассет Менежмент ҮЦК нь хамтын биржээр арилжаалагддаг санг үүсгэн байгуулах баримт бичгийг Биржид ирүүлж Бүртгэлийн хорооны хурлаар хэлэлцэн 2023 оны 5 сарын 2-ны өдөр бүртгэх зөвшөөрөл олгосон.

Бирж нь бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд үнэт цаас гаргах боломжит компаниудтай уулзалт зохион байгуулж мэдээллээр хангаж ажиллаж байна. Мөн бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, материал, ТУЗ-ийн хурлын зар, материалыг хүлээн авч, үнэт цаас гаргагчдаас шаардлагатай мэдээ, мэдээллийг ирүүлэхийг шаардаж ажилласан. Биржийн систем, журмуудын шинэчлэлтэй холбоотойгоор хэрэгцээт мэдээллийг бүртгэлтэй үнэт цаас гаргагчдад тухай бүр хүргэж ажиллаж байна.

Бирж бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх үүднээс Бүртгэлийн хороо болон Нийцүүлэгчийг бүртгэлийн үйл ажиллагаанд оролцуулдаг. 2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар Бүртгэлийн хороо нийт 12 гишүүнтэй бөгөөд нийт 29 нийцүүлэгч Биржид бүртгэлтэй байна. Эдгээр гишүүд нь ажиллаж буй салбартаа 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн болон ёс зүйн хариуцлагатай, хараат бус гишүүд байна.

## Гишүүнчлэл

Бирж нь 2023 оны хагас жилийн байдлаар 23 арилжааны гишүүн, 8 тооцооны шууд гишүүн, 3 тооцооны ерөнхий гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд 1 үнэт цаасны компанитай Арилжааны гишүүнчлэлийн гэрээ, 4 үнэт цаасны компанитай Тооцооны шууд гишүүний гэрээг тус тус байгууллаа. Мөн 5 үнэт цаасны компани Арилжааны гишүүнчлэлийн гэрээ болон мэдээллүүдээ шинэчлэн ирүүлсэн.

Түүнчлэн гишүүдийн үйл ажиллагааг дэмжих бодлогын хүрээнд гишүүдийн жилийн хураамжийг Биржид шинээр үнэт цаас нэмэгдэж, арилжаанд орох хүртэл чөлөөлөх, системд нэвтрэх анхны эрхийг үнэ төлбөргүй болгох зэрэг хөнгөлөлт урамшууллыг хэрэгжүүлж ажиллаж байна.

## Журам, зохицуулалт

Бирж нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд өөрсдийн шимтгэл хураамжийг бууруулан Биржийн “Шимтгэл, хураамжийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус өөрчлөлттэй холбоотойгоор мэргэжлийн байгууллагуудаас санал авсан ба Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулахаар ажиллаж байна.

## Системийн хөгжүүлэлт

Бирж нь 2023 оны хагас жилийн байдлаар арилжаа, тооцооны системийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Системийн хөгжүүлэлт чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Арилжааны системд fix холболтын хөгжүүлэлтүүдийг хийж, туршиж байна.
- Үнэт цаасны компаниудтай хамтарсан туршилт хийж байна.

## II.БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Бизнес хөгжүүлэлт

#### “IPO 45”

- Аж ахуй нэгжүүдэд IPO хийх процессыг илүү хялбар ойлгомжтой болгох зорилгоор “IPO 45” хөтөлбөрийг батлан уулзалт, сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

#### ETF төрлийн бүтээгдэхүүн

- ETF олон улсын судалгаа хийж, Монгол улсад бүтээгдэхүүн гаргахаар оролцогч талууд болон кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд, үнэт цаасны компаниудтай уулзалт хийж, дэд бүтцийн зураглалыг гарган “Инвескор ассет менежмент” болон Голомт кастодиан банктай хамтран ажилласан.

### Хамтын ажиллагаа

#### Нексия Глобал

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж нь Нексия Глобал Монголиа Аудиттай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Үүний хүрээнд биржид бүртгүүлэхээр зэхэж буй компаниудад санхүүгийн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, бүртгүүлсэн компаниудад санхүүгийн тайлагналын олон улсын стандарттай холбоотой зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зорилгоор “Нексия Глобал Монголиа Аудит”-тай хамтран ажиллах юм.

#### Lemon press

“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК хөрөнгийн зах зээл, санхүү, бизнесийн мэдээллийг баталгаат эх сурвалжтай, баримтад үндэслэн, шинэлэг санаа, сонирхолтой байдлаар уншигчдадаа хүргэдэг Lemon Press компанитай хамтран санхүүгийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэж хөрөнгийн зах зээлийн оролцогчдыг ухаалаг шийдвэрт хөтлөхөөр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

#### Market info

Хөрөнгийн зах зээлийн мэдээ мэдээллийг тогтмол, цаг алдалгүй хүргэдэг [www.marketinfo.mn](http://www.marketinfo.mn) сайттай хамтран ажиллах ажиллах гэрээ байгуулж, олон нийтэд

ТОГТМОЛ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙГ ХҮРГЭХЭЭР ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ЭХЛҮҮЛСЭН.



## Сургалт

- Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татаж, IPO хийхээр төлөвлөж буй компаниудын захирлууд, хувьцаа эзэмшигчид, санхүүгийн албаны захирлуудад мэдвэл зохих мэдлэг олгох, зөвлөгөө өгөх, солилцох зорилгоор аудит, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран “IPO-д бэлтгэх нь” сургалт, нетворкинг арга хэмжээг зохион байгуулсан.

**UBX** Ulaanbaatar  
Securities Exchange

**JPA** INTERNATIONAL  
Accounting, Tax, Audit, Advisory  
Mongolia

**McKENZIE & PARTNERS TMZ**  
A member of  
**Nexia**  
International

# IPO - Д БЭЛТГЭХ НЬ

Сургалт, нетворкинг арга хэмжээ

**Зорилго**  
Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татаж, IPO хийхээр төлөвлөж буй компаниудын захирлууд, хувьцаа эзэмшигчид, санхүүгийн албаны захирлуудад мэдвэл зохих мэдлэг олгох, зөвлөгөө өгөх, туршлага солилцох

**Б.Гантулга**  
Гүйцэтгэх захирал  
Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК

**Э.Булган**  
Гүйцэтгэх захирал  
Нексия Глобал Монголиа Аудит ХХК

**М.Энхмэнд**  
Гүйцэтгэх захирал  
Макензи энд Партнерс ТМЗ ХХК

Сентрал Тауэр-ийн 17 давхрын хурлын тахимд

2023.05.30

14:30 – 17:30

Оролцогчдын тоо хязгаартай



### III. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Бирж нийт 477.05 сая ширхэг энгийн хувьцааг эргэлтэд гаргаснаас 301.0 сая ширхэг буюу 63.03 хувийг үүсгэн байгуулагч “Даац инвестмент” ХХК, 30.0 сая ширхэг буюу 6.28 хувийг “Даац менежмент” ХХК эзэмшиж байна. Бусад 146.5 сая ширхэг буюу 30.06 хувийг 30 жижиг хувьцаа эзэмшигч хуваан эзэмшиж байна.

Бирж нь Хаалттай хувьцаат компанийн хэлбэртэй бөгөөд Компанийн эрх барих дээд удирдлага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн чөлөөт цагт Компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх этгээд нь Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### ХЭХ-ийн үйл ажиллагаа

2023 он гарснаар эхний хагас жилд Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 1 удаа хуралдсан байна.

№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо
1	2023.04.24	82.92%	2

*Хүснэгт 3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээлэл*

#### ТУЗ-ийн үйл ажиллагаа

Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны эхний хагас жилд 5 удаа хуралдсан бөгөөд нийт 22 тогтоол гарган ажилласан байна. “Компанийн засаглалын кодекс”-ийг хэрэгжүүлэх, засаглал сайжруулах хүрээнд Цалин урамшууллын бодлого, Компанийн оролцогч талуудтай харилцах, хамтрах ажиллах бодлого зэргийг баталсан.

№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо
1	2023.1.11	77.7%	7
2	2023.2.09	77.7%	3
3	2023.3.10	88.8%	5

4	2023.5.24	77.7%	6
5	2023.6.16	66.6%	1

*Хүснэгт 4 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын мэдээлэл*

#### IV.САНХҮҮ

“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК 2023 оны эхний хагас жилд 2,837,000.00 төгрөгийн үнийн дүнтэй хувьцааны арилжаа хийж, арилжаа тооцооны шимтгэлд 28,962.92 төгрөгийн орлого, бусад үйл ажиллагааны орлогоор 2.5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

2023 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар компанийн балансын нийт хөрөнгийн дүн 2.2 тэрбум төгрөг бөгөөд үүний 16.5 хувийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна.

*Хүснэгт 5. Санхүүгийн тайлангийн хураангуй (сая төгрөгөөр, 2023 оны II улирал)*

№	Санхүүгийн тайлангийн хураангуй үзүүлэлтүүд	Дүн (сая төгрөгөөр)	
		2022.12.31-ны үлдэгдэл	2023.06.30-ны үлдэгдэл
1	<b>Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүд</b>		
1.1	Борлуулалтын орлого	6.46	2.59
1.2	Борлуулалтын өртөг	0.17	-
1.3	Нийт ашиг	6.29	2.59
1.4	Хүүний орлого	0.00	0
1.5	Бусад орлого	0.21	5.37
1.6	Ерөнхий ба удирдлагын зардал	1,128.39	523.04
1.7	Санхүүгийн зардал	57.16	27.73
1.8	Бусад зардал		0.13
1.9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.06	0.00

1.10	Хөрөнгө оруулалт / Үндсэн хөрөнгө борлуулснаас үүссэн олз (гарз)	(25.00)	(1.44)
1.11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,194.19)	(544.37)
1.12	Орлогын татварын зардал	13.00	
1.13	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,207.19)	(544.37)
2	<b>Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд</b>		
2.1	Нийт хөрөнгийн дүн	2,418.62	2,229.12
2.2	Үүнээс: Эргэлтийн хөрөнгийн дүн	380.57	368.59
2.3	Өр төлбөрийн дүн	753.35	1,108.21

“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК

**Утас: (+976) 7000-0501, (+976) 7000-0502**

**Факс: (+976) 7011-3722**

**Имэйл хаяг: [info@ubx.mn](mailto:info@ubx.mn)**

**Хаяг: Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Сүхбаатарын талбай Централ Тауэр, 13 давхар 1309 тоот**